

Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн  
даргын 2025 оны 05 дугаар сарын 15 ны өдрийн  
А/43 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Төвийн даргын А/43 тоот тушаал

Дагаж мөрдөх огноо:

2025.05.15

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2025.05.15

Байгууллагын нэр:

СХДЭМТ

Нэгжийн нэр:

Эмнэлгийн тусламж үйлчилгээний алба

Албан тушаалын нэр:

Онош зүйн тасгийн эрхлэгч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮЭМ-6

Ажлын цаг:

7 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

СХД 13 хороо Залуус гудамж

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн бус

Онцгой нөхцөл:

-

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:** Клиник, эсийн шинжилгээ болон лабораторийн өдөр тутмын чанарын баталгааг хангах, лабораторийн ур чадвар шаардсан нарийн шинжилгээг гүйцэтгэх, дүгнэлт гаргах, стандартын дагуу хийхэд хяналт тавьж, хариуны баталгаажилтыг ханган, лабораторийн эмч, лаборант, туслах ажилтан нарын техник үйл ажиллагааг удирдан зохион байгуулан, тэдний мэдлэг, ур чадвар, хандлага, ажлын гүйцэтгэлийг дээшлүүлэн хамт олны болон ард иргэдэд гомдол санал, чирэгдэлгүй хамтран ажиллах орчныг бүрдүүлэн ажиллахад оршино.

**Албан тушаалын зорилт:**

1. Онош зүйн тасгийн оношилгоо шинжилгээний стандартын хэрэгжилтэнд хяналт тавьж мэргэжил арга зүй болон удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах
2. Амбулаториудад оношилгоо, шинжилгээний гадаад дотоод хяналт тогтмол тавьж бүртгэж байх
3. Шаардлагатай багаж тоног төхөөрөмж, урвалж бодисын хэрэгцээ дутагдлыг урьдчилан тодорхойлж тогтвортой ажиллах хангалтын асуудлыг албаны даргад мэдээлж байх
4. Оношилгоо шинжилгээний багаж хэрэгслэлийн бэлэн байдал, техникийн аюулгүй ажиллагааны горимын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах
5. Урвалж оношлуурын хэрэглээнд хяналт тавьж сар улиралын мэдээ тайлангаар үнэлгээ хийж байх

6. Эмч ажилтнуудын мэдлэг ур чадвар дадлагад үнэлгээ хийж, мэдлэг чадварыг байнга дээшлүүлж байх

7. Халдварын сэгийлэлт хяналтын талаарх тушаал шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаад хяналт тавьж ажиллах

8. Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартын хэрэгжилтийг хангах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Байгууллагын онош зүйн тасгийн зорилго зорилтийн хүрээнд жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллах</p> <p>2. Оношлогоо шинжилгээний стандарт хэрэгжилтэнд мэргэжлийн баг гаргаж хяналт шалгалт хийж, дүгнэлтийг албаны даргад мэдээлж байх</p> <p>3. Тодорхой бус шинжилгээг тодруулах багаж тоног төхөөрөмжийн тохиргоог өдөр бүр шалган нягталж байх</p> <p>4. Лаборант нарыг олон шинжилгээ хийж чаддаг хөрвөн ажиллах чадвартай болгох</p>	Ажлын гүйцэтгэл	<p>1.Г</p> <p>2.Х,Г</p> <p>3.Х,Г</p> <p>4.Г</p>
2 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Лабораторийн тасагт хийгдэж буй шинжилгээнүүдэд гадаад болон дотоод хяналтыг тасралтгүй явуулж, бүртгэлжүүлэн ажиллах</p> <p>2. Гадаад болон дотоод хяналтын үр дүнгийн талаар илэрсэн дутагдлыг арилгах яаралтай арга хэмжээ авч ажиллах</p>	Ажлын гүйцэтгэл, оролцсон арга хэмжээ	<p>1.Х,Г</p> <p>2.Г</p>
3 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Лаборатори, дүрс оношилгоо, үйл ажиллагаа оношзүйн тасаг кабинетуудын урвалж оношлуур, хэрэгслэлүүдийн хангалт бэлэн байдалд хяналт тавьж ажиллах</p> <p>2. Поликлиник, салбар амбулаториудын лабораторийн урвалж оношлуурын сарын хэрэгцээг эмийн санд гарган өгч оношилгоо шинжилгээг тасралтгүй явуулах талаар хамтран хариуцлага хүлээж ажиллана</p> <p>3. Урвалж оношлуурын хангалтын талаар дутагдал доголдол гарах эрсдэлийг урьдчилан тооцож албаны даргад мэдээлэн ажиллана</p>	Ажлын гүйцэтгэл	<p>1.Г</p> <p>2.Г</p> <p>3.Г</p>
4 дүгээр зорилтын	1. Оношилгоо шинжилгээний багаж тоног төхөөрөмжүүдийг ажлын		1.Х

хүрээнд	<p>өмнө бэлтгэх, ажлын үеийн эвдрэлээс сэргийлэх, ажлын дараах үйлчилгээ үйлдлүүдийн журам дараалал санамжийг баримтлан ажиллаж байгаад хяналт тавих байх</p> <p>2. Оношилгоо шинжилгээний багаж хэрэгслэлүүдийн техник аюулгүй ажиллагааны дүрмээр ажиллаж байгааг хянах</p>	Ажлын гүйцэтгэл	2.X
5 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Оношлогоо шинжилгээний дараа урвалж оношлуурын хэрэглээний хүртээмж, стандарт, техник технологийн дагуу үрэгдэл хаягдалгүй ажилласанд хяналт тавих</p> <p>2. Сар бүр урвалж оношлуурын хэрэглээний талаар тайлан гаргаж байх</p>	Ажлын гүйцэтгэл, оролцсон арга хэмжээ	1.X  2.Г
6 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Эмч лаборант нарыг олон аппаратанд ажиллуулж шинжилгээ хийх орлон ажиллах дуудлагаар ирж ажиллах зэрэгт мэдлэг чадвар дадлагатай болгох</p> <p>2. Эмч мэргэжилтнүүдэд шинжилгээний хариуг уншиж буй чадварыг үнэлэх ,сургах ажилд дэмжлэг туслалцаа үзүүлж байх</p>	Ажлын гүйцэтгэл, оролцсон арга хэмжээ	1.Г  2.Г
7 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Лабораторийн тасгийн халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагааны хэрэгжилтэнд онцгой анхаарч байгууллагын хяналтын албадууд тогтмол ажиллаж байгаа талаар албаны даргад мэдээлж байх</p> <p>2. Лабораторийн тасгийн эмч лаборант шил угаагч цэвэрлэгч ажилтан бүрийн халдварын сэргийлэлт хяналтын талаарх мэдлэг чадвар дадлыг улирал тутамд дотоодын хяналтаар шалган мэдээлж ажиллах</p> <p>3. Лабораторын оношлогоо шинжилгээний үйл ажиллагааны эхлэл, явц, төгсгөлийн үеийн хамгаалах хэрэгслэл, халдваргүйтгэл ариутгалын үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй материал бодисын хангалтын талаар хяналт тавьж албаны даргад мэдээлэн ажиллах</p> <p>4. Үйлчлүүлэгчийн аюулгүй ажиллагааг ханган ажиллах</p> <p>5. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, стандартыг мөрдөн ажиллах, чанар сайжруулах чиглэлээр идэвх, санаачлагатай ажиллах. Чанарын албанаас өгсөн үүрэг даалгавар болон сургалт үйл ажиллагаанд идэвхитэй оролцох</p> <p>6. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу</p>	Ажлын гүйцэтгэл, оролцсон арга хэмжээ	1.Г  2.Г  3.Г  4.Г  5.Г

	хэрэглэж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг чандлан сахин, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн хүрээнд ажиллана.		6.Г
8 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Нэгжийн ажилтнуудыг ЧУТ-ын талаарх сургалтад хамруулах, ойлголтыг түгээх ажлыг удирдан зохион байгуулах.</p> <p>2. Байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог (ISO 9001:2015 стандарт) хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулахад нэгжийн хэмжээнд манлайлал үзүүлэх.</p> <p>3. Хариуцсан нэгжийн үйл ажиллагааг стандартын дагуу төлөвлөж, хэрэгжүүлж, хянаж, үнэлэх.</p> <p>4. Чанарын удирдлагын баримт бичгүүдтэй танилцах, шинэчлэлт, хэрэгжилтийг хянах, оролцох</p> <p>5. Өөрийн нэгжид хийгдэх дотоод аудит, үнэлгээнд хамрагдах, шаардлагатай мэдээлэл, нотолгоог бүрдүүлэх.</p> <p>6. Хариуцсан үйл ажиллагаанд хамаарах эрсдэл, боломжийг тодорхойлох, арга хэмжээ төлөвлөх, хэрэгжилтийг хангах.</p> <p>7. Сайжруулалтын санал гаргах, гүйцэтгэлийг хянах, үр дүнг сайжруулах ажлыг манлайлах.</p>	Ажлын гүйцэтгэл	<p>1. Г, Ш</p> <p>2. Г, Т</p> <p>3. Г, Х</p> <p>4. Г, Х</p> <p>5. Г, Т</p> <p>6. Г, Ш</p> <p>7. Г, Х</p>

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

<b>Боловсрол</b>	-АУ-ны бакалавр болон түүнээс дээш. -Лабораторийн эмчийн мэргэжилтэй. -Эмчийн мэргэжлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан байх
<b>Мэргэжил</b>	Их Эмч
<b>Мэргэшил</b>	Их эмчийн ахлах, тэргүүлэх зэрэгтэй байх
<b>Туршлага</b>	Лабораторийн эмчээр 5-аас доошгүй жил ажилласан байх
<b>Ур чадвар</b>	- Удирдан зохион байгуулах, өөрийгөө ойлгуулах, танилцуулах - Сурган заах арга зүй эзэмшсэн Багаар ажиллах

### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан орлогч дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Оношзүйн тасгийн лабораторийн эмч,лаборант,шил угаагч	Бусад харилцах субъект - Клиникийн нэгдсэн эмнэлэг, нарийн мэргэжлийн төвүүд - ЭТУГ, Чанарын баталгаажилтын албатай мэргэжлийн зөвшөөрлийн талаар - ЗГХА-Эрүүл мэндийн газар - Анагаах ухааны боловсрол олгодог сургууль Төрийн болон төрийн бус байгууллага

**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:
<p>Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв</p> <p>Албан тушаал: Хүний нөөцийн менежер</p> <p><i>В. Мичидмаа</i> Батболдын Мичидмаа</p> <p>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)</p> <p>202<sup>5</sup> оны <sup>05</sup> дугаар сарын <sup>15</sup> -ны өдөр</p>	<p>Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв</p> <p>Албан тушаал: <b>СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА</b></p> <p><i>М. Чойжилсүрэнгийн</i> Чойжилсүрэнгийн</p> <p>Өнөрсайхан</p> <p>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)</p> <p>202<sup>5</sup> оны <sup>05</sup> дугаар сарын <sup>15</sup> -ны өдөр</p>

Handwritten signature or scribble in blue ink.